

ШУТИС-ийн оюутны сайн дурын клубийн хаврын улирлын ажлын тайлан

ШУТИС-ийн оюутны сайн дурын клубийн хаврын улирлын ажлын тайланхэлэлцэх хурал 2016 оны 05 сарын 20 ны өдөр ШУТТномын сангийн 604 тоот танхимд 10:00-13:00 цагийн хооронд боллоо. Мэргэжлийн клубүүдийн тайланг бүрэлдэхүүн сургуулиуд дээр хэлэлцэгдэнэ.

ШУТИС-ийн тус тайлангийн хурлын үйл ажиллагаатай танилцах ажлын хэсэгт ОХҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа, мэргэжилтэн Х.Оюунхишиг, Б.Намхайнямбуу, Инновацийн төвийн мэргэжилтэн Л.Бадрах нар хамтран ажиллав.




Хуралд: AIESEC-MUST клуб, EMPOWERMENT клуб, Хөгжлийн жигүүр клуб, Багшийн туслах оюутан клуб, Герман хэлний клуб, Хятад хэлний клуб, Тэмүүлэл клуб, Мэргэн шагайн харваа клуб, My clu, Ойхон клубүүд оролцов.

Клубүүд тайлангаа тус бүртээ хэлэлцүүлж шаардлагтай байгаа зүйлсийн талаар саналаа тавьж баяв.

AIESEC-MUST клуб- тус клуб нь 88 гишүүнтэй нийт 8 томоохон үйл ажиллагааг явуулсан нийт 1000 гаруй оюутанг хамруулсан, 3 оюутан солилцооны хөтөлбөрт хамруулсан, гадаадаас солилцоогоор багш, оюутан авах ажил эрчимтэй явагдаж байна. Нийт оюутнуудад ярианы англи хэлний сургалтыг хүргэж байна.



EMPOWERMENT клуб нь 30 гаруй гишүүдтэй, Гишүүддээ чадавхжуулах сургалт явуулж байна. Нийт 7 орчим төрлийн үйл ажиллагаа зохион байгуулан оролцсон. Үйл ажиллагаагаа ний 70 орчим оюутанд хүргэсэн. Сургалтын чиглэл- ярих чадвар, ойлгол, эфирийн соёл, төсөл, диплом бичих, илтгэх, нээлттэй хэлэлцүүлэг, шийдэл дээр ажиллах зэрэг болно. Энэ хичээлийн жил хөтлөгчийн клубтэй нэгтгэсэн ч мэтгэлцээн, хөтлөгч 2-ийн үйл ажиллагаа өөр байсан тул бид хөтлөгчидөд чиглэсэн үйл ажиллагааг явуулж чадаагүй. Иймээс хөтлөгчийн клуб тусдаа явах нь дээр байсан.



ХӨГЖЛИЙН ЖИГҮҮР КЛУБ нь 14 гишүүнтэй 6 төрлийн үйл ажиллагааг явуулсан 500 гаруй оюутан хамруулсан, “Багш оюутны долоо хоног” хөтөлбөрийн үйл ажиллагаанд ОХҮА, ЗЦГ-тай хамтран ажилласан. Бид хамгийн гол шинэ оюутны төлөвшил, суралцах үйл ажиллагаанд нь чиглэсэн тусламжийн үйлчилгээг үзүүлж байна. Зөвлөх багшаар Д.Бурмаа багш ажиллаж байна.

БАГШИЙН ТУСЛАХ ОЮУТАН КЛУБ оюутны хичээлийн хоцрогдол арилгах тэдэнд туслах зорилгоор суурь эрдмийн 5, мэргэжлийн чиглэлийн 2 хичээлээр хичээлээр сургалт зөвлөгөөг V-XVI долоо хоногт явуулж сүүлийн 2 долоо хоногийн бямба гарагт зорилтот 30 онооны давтлагийг өгч ажилласан, мөн клубүүдийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан үйл ажиллагаанд нийт 4000 орчим оюутан хамрагдсан. Үйл ажиллагааг тогтмол сайжруулан ажиллахын тулд оюутнуудаас судалгааг авсан. Зөвлөх багшаар А.Эрдэнэсүвд багш ажиллаж байна.




ГЕРМАН ХЭЛНИЙ КЛУБ НЬ герман хэл судлаж буй оюутнуудыг хамруулдаг шинээр байгуулагдсан клуб хагас жилийн хугацаанд 5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 150 гаруй оюутанг хамруулсан. Зөвлөх багшаар Д.Сэржмядаг багш ажиллаж байна.



ХЯТАД ХЭЛНИЙ КЛУБ НЬ 60 шигүүнтэй клубийн гишүүдэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулж байна, Клубийн гишүүдээс 3 оюутанд шилдэг гишүүний өргөмжлөл гардууллаа. Клубийн гишүүдээс 25 оюутан эрдэм шинжилгээний хуралд оролцсон. Зөвлөх багшаар Ц.Эрдэнэзаяа багш ажиллаж байна. Зөвлөх багшаар Ц.Эрдэнэзаяа багш ажиллаж байна.



ТЭМҮҮЛЭЛ КЛУБ НЬ ахмад болон өсвөр насны 300 гаруй гишүүдтэй тогтмол үйл ажиллагаанд оролцдог 40 гишүүдтэй Эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн уртын богины аялал зохион байгуулдаг энэ хагас жилийн хүрээнд нийт 8 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан зөвхөн оюутнуудаас 80 гаруй оюутан хамрагдсан Зөвлөх багшаар Б.Туяа багш ажиллаж байна.



МЭРГЭН ШАГАЙН ХАРВАА КЛУБ НЬ 80 тогтмол үйл ажиллагаанд оролцдог гишүүдтэй 6 төрлийн үйл ажиллагаа, Шагайн улсын аврага шалгаруулах тэмцээнийг анх удаа их дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан. МШХ-ноос тэмцээн зохион байгуулах эрх олгосон мөн МШХ-ны хүндэт өргөмжлөл, Юнескогийн батламжийг тус клубд гардуулан өгсөн байна.



МУ CLUB НЬ сайн дурын 1000 гаруй гишүүдтэй тогтмол үйл ажиллагаанд оролцдог гишүүдийн тоо 500 гаруй байна. Зөвлөх багшаар Д.Сэрдарам ажиллаж байна.



ОЙХОН КЛУБ НЬ байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж цуврал уулзалт, cover night уралдаан зэргийг нийт 8 ажил зохион байгуулан олон оюутныг хамруулж байна. Зөвлөх багшаар Ц.Түвшинтөр ажиллаж байна.



ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА